

СПОРТЫН АРБИТРЫН ХЭЛЭЛЦЭЭР ХИЙХ АРГАЧЛАЛ

Их спортын олон улсын болон үндэсний төрөл бүрийн уралдаан тэмцээнийг эх орондоо болон гадаад улсад зохион байгуулах, оролцох бүрд тамирчдын виз зөвшөөрөл, унааны зардал, буудал, хоол, техникийн зөвлөлгөөн, дүрэм журамаас гадна спортын гэрээ байгуулах шаардлага зүй ёсоор урган гарч ирнэ. Энэхүү гэрээндээ “Маргааныг Монголын Спортын Олон улсын болон Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ” гэж зүйлчлэн тусгаж болно.

Спортын арга хэмжээний үеэр төрөл бүрийн маргаан, санал зөрөлдөөн үүсдэг бөгөөд үүнийг харилцагч талууд эвлэрч, харилцан ойлголцох, буулт хийх замаар шийдвэрлэж болдог хамгийн хямд, цаг хугацаа, зардал хэмнэсэн шилмэл гарц бий. Харин хоорондоо тохиролцохгүй, маргаанаа шийдэж чадахгүй бол шүүхийн болон шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэхээс өөр замгүй. “**Шүүхийн бус**” гэдэгт маргааныг шийдвэрлэх эрхийг хуулиар олгосон эрх бүхий этгээд (Татварын маргаан таслах зөвлөл, Хөдөлмөрийн Эвлэрүүлэн зуучлах төв г.м.), Эвлэрүүлэн зуучлах бусад газрууд болон Арбитр, түүн дотроо шинээр зохион байгуулагдаж байгаа Монголын Спортын арбитр зүй ёсоор орно.

Маргааныг хөндлөнгийн этгээд болох шүүх, арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэх хууль зүйн үндэслэл нь: Иргэний хуулийн **9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт**

9.1.Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байна.

9.2.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрхээ хамгаалуулах этгээдийг хуульд заасны дагуу сонгох эрхтэй.

9.3.Иргэний эрх зүйн хамгаалалтыг **шүүх, арбитр** хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ” гэж хуульчилсны дагуу өөрийн спортын эрх, эрх чөлөө, ашиг сонирхол хохирсон гэж үзэж байгаа этгээд маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг сонгоно.

Маргааныг арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэхийн тулд:

нэгдүгээрт, Спортын арга хэмжээг зохион байгуулах гэрээндээ шууд “Маргааныг Монголын Спортын Олон улсын болон Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ” гэж зүйлчлэн тусгах,

хоёрдугаарт, маргаан үүссэний дараа талууд маргаанаа спортын арбитраар шийдвэрлүүлэхээ тохиролцох,

гуравдугаарт, спортын арбитрын хэлэлцээргүйч шууд хандах, нөгөө тал үүнийг нь эсэргүүцээгүй хүлээн зөвшөөрсөн нөхцөлд спортын арбитрын хэлэлцээр хийсэнтэй адилтган үзэх,

дөрөвдүгээрт, Спортын Арбитрын бие даасан тусгай хэлэлцээр хийх явдал чухал бөгөөд давуу талтай юм. Үүнээс бид:

Спортын арга хэмжээг зохион байгуулах гэрээндээ “Маргааныг Монголын Спортын Олон улсын болон Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ” гэж зүйлчлэх гэдэг нь жишээлбэл, Гэрээнд;

5.1. Спортын харилцаанаас үүссэн маргаан, санал зөрөлдөөнийг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

5.2. Хэрвээ талууд тохиролцож чадаагүй бол маргааныг Монголын Олон улсын болон Үндэсний Спортын арбитраар шийдвэрлүүлнэ” гэж заахыг хэлнэ.

Одоо Спортын Арбитрын бие даасан тусгай хэлэлцээрийг хэрхэн хийх аргачлалын талаар авч үзье.

СПОРТЫН АРБИТРЫН ХЭЛЭЛЦЭЭР

Огноо

№

Улаанбаатар хот

Спортын Арбитрын хэлэлцээрт оролцогч нэг талаас: “Олимп” ХХК, түүнийг төлөөлөн спортын арга хэмжээ хариуцсан менежер Ц.Мөнхжаргал, нөгөө талаас: “Аварга” ХХК, түүнийг төлөөлж спортын гадаад арга хэмжээний менежер Т.Болор-Отгон нар \Цаашид хамтад нь “талууд” гэх\ Иргэний хууль, Арбитрын тухай хууль, Биеийн тамир спорт тухай хууль, бусад хороо, нийгэмлэгийн дүрэм, журмыг үндэслэн, дараахи нөхцөлөөр гэрээ байгуулав.

Нэг. Нийтлэг заалт

1.1. Энэхүү гэрээний үндсэн зорилго нь “Олимп” ХХК болон “Аварга” ХХК-ийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд спортын арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Олимп” ХХК болон “Аварга” ХХК-ийн хооронд 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 1\13 тоот хөл бөмбөгийн тэмцээн зохион байгуулах гэрээ хийгдсэн бөгөөд тэмцээнийг Сэлэнгэ аймагт 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хийхээр тохиролцсон болно.

1.3. Дээрхи гэрээг хэрэгжүүлэх явцад маргаан үүсвэл талууд шүүхийн бус журмаар буюу эхний ээлжинд харилцан тохиролцож эвлэрэх, буулт хийх, ойлголцох журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

1.4. Үүнд: талууд маргаанаа спортын эвлэрүүлэн зуучлах төвөөр шийдвэрлүүлж болно. Спортын эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрвэл арбитрын ажиллагааг дуусгавар болгож, эвлэрлийн нөхцөлийг арбитрын шийдвэрт тусгаж баталгаажуулна.

1.5. **Маргаан үүсээд түүнийгээ дээрх аргаар шийдвэрлэж чадахгүй хуанлийн 30 хоног өнгөрвөл** өөрийн спортын эрх, эрх чөлөө, ашиг сонирхол хохирсон гэж үзэж байгаа тал “спортын байнгын арбитр”-т нэхэмжлэл гаргах эрх нээгдэнэ.

Хоёр. Арбитрын харьяалал ба бүрэлдэхүүн

2.1. Спортын Арбитрын харьяаллын хэрэг нь Монголын Олон улсын болон Үндэсний Спортын арбитраар шийдвэрлэгдэнэ. Энэхүү Спортын хэлэлцээр Арбитрын тухай хуулийн 9 дүгээрийн 9.1 дэх зүйл. Арбитрын харьяаллын маргаан, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар

шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан арбитрын харьяалалд хамаарна” гэсэн зохицуулалтыг үндэслэн хуулийн хүчинтөгөлдөр хэлэлцээр гэдгийг хүлээн зөвшөөрөв.

2.2. Спортын Арбитрын ажиллагаа явуулах газрыг Улаанбаатар хот гэж харилцан тохиролцов.

2.3. Спортын арбитрын бүрэлдэхүүний тоо \1 эсхүл 3\ байхаар тохиролцов. \Эсхүл “талууд Спортын арбитрчийн тооны талаар өөр өөр саналтай байсан учир харилцан тохиролцож чадаагүй болно” гэх\.

2.4. Талуудын хувьд Спортын арбитрч нарын нэрсийн жагсаалтаас сонголтоо чөлөөтэй хийх ба нөгөө талын арбитрчийг хэргийг шийдвэрлэхэд хуульд заасан үндэслэлээр оролцох боломжгүйгээс бусад тохиолдолд сонголтод хүндэтгэлтэй хандана.

Гурав. Арбитрын хуралдаан

3.1. Арбитрын хуралдааныг талуудыг оролцуулан мэтгэлцэх журмаар хийлгэнэ, \эсхүл талууд арбитрч нарт итгэл хүлээлгэн өөрсдөө хуралд оролцохгүйгээр, зөвхөн хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт дээр түшиглэн шийдвэр гаргах гэсэн хоёрдогч хувилбарыг сонгож болно\.

3.2. Хуралдаанд нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн бүрэн эрхт төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, гуравдагч этгээд нарыг оролцуулна. Өөр хүн төлөөлүүлэн оролцуулах бол итгэмжлэл, өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн тухайд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг тус тус хавсаргаж өгнө.

3.3. Хуралдааныг Монгол Улсын хэл дээр явуулна. Хэрвээ талууд болон аль нэг тал нь Монгол хэл мэдэхгүй, гадаадын харьяат болон харьяалалгүй бол өөрсдөө орчуулагчаа олох, хөлсийг төлөх ёстой. Эсхүл Спортын арбитрын байгууллагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орчуулга хийхэр авсан орчуулагч томилуулахаар тохиролцож болно. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй \хэлгүй, сохор, дүлий\ тал нь дохио зангааны мэргэжлийн хэлмэрч оролцуулахаар тохирч болох юм\.

3.4. Хуралдааныг бүхэлд нь нээлттэй, эсхүл хаалттай хийлгүүлэхээр, эсхүл зарим хэсгийг хаалттай, бусад хэсгийг нээлттэй хийлгүүлэхээр тохиролцож болно. \Улсын, байгууллагын, хувь хүний нууцтай холбоотой асуудал үүсэх эсэхээс шууд хамаарч хуралдааны дээрхи хэлбэрийг сонгох юм\.

3.5. Спортын арбитрын ажиллагааны явцад тодорхой болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүргийг хүлээв.

Дөрөв. Хэрэглэх эрх зүй

4.1. Маргааныг шийдвэрлүүлэхдээ Олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, Худалдааны хууль, Иргэний хууль, Арбитрын тухай, Биеийн тамир спортын тухай хуулийг хэрэглэнэ. Үүнд \тус улсын материаллаг эрх зүйн бусад хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэнэ\.

4.2. Монгол Улсын Дээд шүүхийн Арбитрын хуулийг тайлбаралсан тогтоол, “Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм”, “Арбитрын үндсэн болон нэмэлт зардлыг тооцох журам” зэрэг шууд холбогдох зохицуулалтыг мөн дагаж мөрдөнө.

Тав. Нотлох баримтад тавигдах шаардлага.

5.1. Талууд шинжээч /санхүүгийн, эдийн засгийн, хими, биологийн, кримналистик г.м/ шинжээчийг ... хүний бүрэлдэхүүнтэй томилох, шинжээчийн зардлыг хүсэлт гаргасан тал эхний ээлжинд хариуцах ба нэхэмжлэл хангагдсан буюу хэрэгсэхгүй болгосон хэмжээнд ногдох хувиар нөхөн төлбөр хийнэ. \ Эсхүл шинжээч томилуулах шаардлагагүй гэж үзвэл энэ тухайгаа баталгаажуулж болно \.

5.2. Шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус буюу үндэслэлгүй, эсхүл шинжээч нар зөрүүтэй дүгнэлт гаргасан гэж үзвэл өөр шинжээчээр дахин шинжилгээ хийлгүүлэх хүсэлт гаргах эрхтэй болно.

5.2. Гадаад хэл дээр байгаа нотлох баримтыг албан ёсны зөвшөөрөл бүхий орчуулагч, хэлмэрчээр Монгол хэл дээр орчуулуулж, нотариатаар гэрчлүүлэх зардлыг арбитрт эдгээр баримтыг хүргүүлж байгаа тал өөрсдөө хариуцна.

Зургаа. Бусад асуудал

6.1.Талууд Гэрээний хаяг өөрчлөгдсөн бол нөгөө талдаа нэн дариу мэдэгдэхээр тохиролцов. Хэрвээ шинэ хаягаа өгөөгүй нөхцөлд гэрээнд заасан хуучин хаягаар шуудангийн баталгаат илгээмжээр хүргүүлсэн өдрийг уг баримт бичгийг хүлээн авсан өдөрт тооцно.

6.2. Спортын Арбитрын хураамжийг “Арбитрын үндсэн болон нэмэлт зардлыг тооцох журам”-д заасныг үндэслэн тогтоосон хэмжээгээр нэхэмжлэл гаргаж байгаа тал эхний ээлжинд төлнө. Харин нэхэмжлэлийн шаардлага хангагдсан хэмжээгээр тооцож хариуцагч тал буцаан төлөлт хийнэ.

6.3. Спортын Арбитрын шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан олон нийтэд ил тод зарлахгүй гэж тохиролцов. Хэрвээ сургалт, судалгааны зориулалтаар хэвлэлд нийтлэхээр бол компани болон хувь хүний нэрийг өөрчлөх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Арбитрын шийдвэр

7.1. Спортын арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө буюу арбитрын ажиллагааны явцад талууд арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулахаар арбитр болон анхан шатны шүүхэд хүсэлт гаргах тэгш эрхтэй байна.

7.2. Спортын арбитрын бүрэлдэхүүн шийдвэрээ олонхийн саналаар гаргасан бол талууд хүндэтгэн хүлээн зөвшөөрнө. Гэхдээ Арбитрын тухай хуулийн 47.2-т заасан үндэслэлүүдийн аль нэг байгаа гэж үзсэн тал давж заалдах шатны шүүхэд хандаж гомдол гаргах эрхтэй байна.

7.3. Арбитрын үндсэн шийдвэр болон Арбитрын тухай хуулийн 45.3-т заасан шийдвэр гарснаар арбитрын ажиллагаа дуусгавар болсонд тооцно.

7.4. Арбитрын шийдвэрийг холбогдох тал заавал биелүүлэх үүрэг хүлээв.

Найм. Талуудын албан ёсны хаяг:

Нэхэмжлэгч:

Хариуцагч:

Хаяг:

Хаяг:

Утас:

Утас:

Гарын үсэг, тамга тэмдэг: _____

Гарын үсэг: тамга тэмдэг: _____

Хэрвээ Та бүхэн ийм хэлэлцээрийг хийх аваас дараахи давуу байдлыг мэдрэх болно. Үүнд: Арбитр 1 шаттай бол, шүүх 3 шаттай, цаг хугацаа бизнест алт учир хугацаа хожих, Арбитрт тэмдэгтийн хураамжийг 1 удаа төлдөг бол, шүүхэд 3 удаа төлөхөд хүрдэг, маргааныг шийдвэрлүүлэх арбитрчаа өөрөө сонгодог, арбитрын хурлыг хэрхэн хийх аргачлалыг өөрсдөө тохиролцон тогтоодог, арбитрын шийдвэр шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх хуулийн хүчинтэй байдаг, манай улс олон улсын конвенцид нэгдэн орсон тул тус арбитрын шийдвэр дэлхийн 170 орчим улсад биелэгдэх боломжтой, Монголын Олон Улсын болон Үндэсний спортын арбитр гэсэн шинэ нэршилтэй болсон, дэргэдээ Эвлэрүүлэн зуучлах төв байгуулсан, Арбитрчдын бүрэлдэхүүнд нь ОХУ, БНХАУ, Япон, БНСУ зэрэг олон орны нэр хүндтэй гадаадын гишүүн арбитрчтай, Олон Улсын Спортын Арбитрын байгууллагатай нягт холбоотой ажиллаж байгаа болно.

Энэхүү Спортын хэлэлцээр нь загвар учраас Та бүхэн бүтээлчээр хэрэглэн, шинэлэг санаа, өөрсдийн Спортын безнэс үйл ажиллагааны онцлогт тохируулан улам бүр, баяжуулан, бас шүүмжлэлтэй хандана гэдэгт эргэлзэхгүй байна.